

Үндсэн хууль дахь хуучирсан үгийн тухай

Гансүхийн АРИУН-ОНОН*

Монгол улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

Хэл шинжлэлийн салбарын ЭШДаА, доктор (Ph.D)

Хураангуй:

Хэлний үгийн сан нь нийгмийн хөгжлийн хувьслыг даган байнга өөрчлөгддөг бөгөөд зарим үг хэллэгийн хэрэглээ нь хязгаарлагдаж идэвхгүй үгийн санд орж байхад яг эсрэгээрээ шинэ юм үзэгдэл, ойлголт, ухагдахууныг заасан шинэ үг хэллэг бий болж сэлбэгдэн баяжиж байдаг.

Монгол хэлний үгийг идэвх, хэрэглээгээр нь идэвхтэй ба идэвхгүй гэж ангилж идэвхтэй үгийг нэн идэвхтэй буюу ярианы хэлний үг, жирийн идэвхтэй буюу түгээмэл хэрэгцээт үг гэж ангилдаг. Түгээмэл хэрэгцээт үг гэж үгийн сангийн ихэнх хувийг бүрэлдүүлдэг, бүх насны бүхий л мэргэжлийн хүмүүс мэдэж хэрэглэдэг, хүний нийгмийн харилцаа, амьдралын түгээмэл үзэгдлийг заан нэрлэсэн үгийг хэлнэ. Харин хүмүүс тэр бүр хэрэглэдэггүй, тодорхой мэргэжлийн бүлэг хүмүүсийн хэрэгцээт үг хэллэгийг идэвхгүй үг гэнэ. Монгол хэлний идэвхгүй үг хэллэгт нутгийн аялгууны үгс, этгээд бүдүүлэг үгс, мэргэжлийн болон нэр томьёоны үг, шинэ ба хуучин үг зэрэг хамруулж үздэг. Энэ өгүүлэлд 1924, 1940, 1960 оны үндсэн хуулийн хуучин үг хэллэгт хийсэн ажиглалтыг танилцуулна.

Түлхүүр үгс: хуулийн үг хэллэг, хуучин үг, түүхэн үг, үндсэн хууль

Удиртгал

Үгийн сан буюу үгс нь нийгмийн амьдралд гарч буй аливаа хувьсал өөрчлөлтийг хамгийн түрүүнд тусгадаг хамгийн мэдрэмтгий хөдөлгөөнт хэсэг юм. Нийгмийн амьдралд ямар нэг шинэ юм үзэгдэл, ойлголт бий болоход тэр ойлголтыг нэрлэх үгийн сангийн шинэ нэгж бий болдог бол эсрэгээрээ хэлэнд нэрлэж байсан нэгж хуучирч идэвхгүй үгийн санд шилжиж, хэрэглээ нь хязгаарлагдах нь ч бий. Хэлний үгийн сангийн идэвхтэй үгс нь түүхэн тодорхой цаг үед хэрэглэгдэж байсан боловч нийгмийн хөгжлийн явцад хэрэглэгдэхээ

* © Г.Ариун-Онон 2024
Email: ariunonong@mas.ac.mn

больдог. Гэвч үг хуучрах нь үгийн сангийн хэрэглээнээс бүрмөсөн гарч байгаа хэрэг бус, идэвхтэй үгийн хүрээнээс идэвхгүй үгийн нөөцөд шилжиж байгаа хэрэг юм. Үг хуучрах үйл явц нь нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт болоход, нэн ялангуяа нийгмийн байгуулал хувиран өөрчлөгдөхөд илүү хурдацтай болдог. Тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний өдөр тутмын хэрэгцээнээс гарсан, эсвэл гарч байгаа идэвхгүй үг хэллэгийг хуучин үг хэллэг гэнэ.

Хуучирсан үгийн тухайд

Хэл шинжлэлийн эрдэмтэд хуучин үгийг дараах маягаар тодорхойлж ирсэн байна. Н.Нансалмаа “Хэлний идэвхтэй үгийн сангийн хэрэглээнээс гарч тэр бүр хэрэглэгдэхгүй болон идэвхгүй үгийн санд шилжсэн үгийн сангийн нэгжүүдийг хуучин үг хэллэг гэнэ”, Ц.Өлзийхутаг “Монгол хэлний үгсийн сангийн дотор одоо үеийн хүмүүсийн аман ярианы ба бичгийн хэлний хэрэгцээнд орохоо больсон буюу идэвхтэй хэрэглэгдэхээ больсон нэлээд үг байна. Ийнхүү одоогийн ярианы аман хэлэнд хэрэглэгдэхээ нэгэнт больсон бөгөөд ард нийтийн олонх нь ойлгохоо больсон үгийг хуучин үг гэнэ. Хуучин үгийн зарим хэсэг нь хэлэнд хэрэглэгдэхгүй, толь бичигт орохгүй, хүнд хэлж сонсгоход харь хэлний үг мэт санагдах ба хэрэг болгон хэрэглэхэд тайлбар зүүлт хэрэгтэй болдог байна. Хуучин үгийг уран зохиол, ёслол хүндэтгэл зэрэгт хэрэглэдэг.” (1979:86-90)

Хуучин үгийг түүхэн (historism) ба хуучин (archaism) гэж ангилдаг. Нийгмийн хөгжлийн явцад зарим юм элэгдэн хуучирч, огт хэрэглэгдэхгүй болохын хамт түүнийг заан нэрлэж байсан үг нь мөн хэрэгцээнээс гарч зөвхөн өнгөрсөн үеийн түүхэн байдлыг тодотгон үзүүлэхэд сэргээн хэрэглэх явдлыг түүхэн үг гэнэ. (2022:78) Д.Отгонсүрэн “Түүхийн тодорхой нэгэн үед идэвхтэй хэрэглэгдэж байгаад уг юмс үзэгдэл ойлголт үгүй болмогц хэл ярианд орохоо больж байгаа үгийг түүхэн үг хэллэг гэдэг” гэжээ. Ц.Сүхбаатар 1. Эртний үг 2. Түүхэн үг 3. Хуучирсан гэж гурав ангилж авч үзсэн байдаг. Мөн хуучин үгийн бүрэлдэхүүнд байгаа үгийг хэрэглээ утгаар нь бүрмөсөн мартагдсан, мартагдаж байгаа, мартаагүй боловч хэрэглэгдэхгүй байгаа үгс гэж үзэж болно гэжээ. (2012: 134)

Түүхэн үг: Түүхэн үг хэллэгийн утга нь ойлгомжгүй болсон байдаг тул толь бичиг ашиглах, эсвэл тайлбарлах аргаар ойлгуулах хэрэгтэй болдог. Хуучирсан байдлаар нь хуучин үг хэллэгийг а. Тухайн хэлээр хэлэлцэгчдэд ойлгомжгүй болсон учир толь бичигт хандах шаардлагатай үг хэллэг б. Тухайн хэлээр хэлэлцэгчдэд ойлгомжтой боловч тодорхой хүрээ, тодорхой бичвэрт тодорхой зорилгоор ашигладаг идэвхгүй үг хэллэг гэж хувааж болно. Хуучин үг гэдэг нь уг ухагдахуун нь байгаа боловч өөр үгээр нэрших болсон үгийг хэлнэ. Харин зарим юм үзэгдэл ойлголт нийгмийн хөгжлийн өөрчлөлт хөгжлийн нөлөөгөөр цаг хугацааны явцад хуучирч орхигдох бөгөөд тэдгээрийг нэрлэж байсан үг нь бас хамт орхигдож хэлэнд идэвхтэй үүрэг гүйцэтгэхээ болих ба ийм үгсийг түүхэн үг гэж ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл ухагдахуунгүй болсон үгийг

хэлнэ.

Хуулийн үгийн санд түүхэн үг хэллэг элбэг тохиолдоно. Жишээ нь: Манжийн үеийн есөн эрүү шүүлт. Жишээ нь “Хэрвээ байцаах захирах түшмэл вайлин, харьяат захирах хүнд агсан өр тавих ба эд юмыг дайчлах болбаас наян чавчирга занч” гэжээ. “Чавчирга” гэдэг нь хэрэгтнийг доош харуулан хэвтүүлж алцайлгаад, нүцгэн хөл тус бүр дээр хүн суухад шийтгэл гүйцэтгэгч нь толгойн тус газар суугаад 60-100 банздах эрүү шүүлт юм. “Шаахай” гэдэг нь хүний хоёр хацрыг тус бүр 1-40 удаа цохихыг хэлнэ. Хүний хацрын арьс, мах шалбаран урагдаж, шүдгүй болоход хүргэдэг. “Шахаа” заалдсан заалдагдсан хоёр этгээдэд хөндлөн гэрч тэмдэг, сэжиг сэдэвгүй бөгөөд хагалбар болгох зүйлгүй учир бузар муухай юмны доогуур шургуулан ам алдуулж тангараглуулдаг ёс), “Ширлэх” гэдэг нь зөвхөн толгойг нь гарган, нойтон ширэнд боож, ширнийхээ амыг үдээрээр үдэхийг хэлнэ. Зуны халуунд хатаж, өвлийн хүйтэнд барьж хөлдөнө. “Хулсан хадаас” гэдэг нь хүний хумсны завсраар хадаас шааж шийтгэдэг харгис эрүү шүүлт. “Хүллэгээ” гэдэг нь нарийн шанз олс буюу сурыг усанд норгож байгаад хүний хоёр гар, хөлийг нийлүүлэн арьс маханд нь далд ортол чангалж хүлж муужруулан унагадаг, “Сараалж” гэдэг нь хурц ирмэгтэй мод буюу эсвэл хавтгай модон дээр чулуун хайрга асгаж, түүн дээр хүнийг сөхрөөж суулгаж хоёр тахимыг дамнуулан урт бүдүүн бөөрөнхий модыг хавчуулан түүний хоёр үзүүр дээр нэжгээд хүмүүс талхигдан гишгэхийг хэлнэ. “Дүүжлүүр” гэдэг нь хүнийг шүүхдээ 7 буюу 9 туйпуун дээр зогсоож хоёр гарын эрхий хуруугаар нь цах модонд дүүжлэн хөл доорх туйпууг нэг нэгээр нь сугалан авахад хүний эрхий хуруу тасарч тахир дутуу болдог эрүү шүүлт. “Дөнгө” гэдэг хүний хүзүүнд өмсгөхөөр тохируулсан дундаа нүхтэй зүймэл дөрвөлжин банзыг хэлнэ. Дээр дурдсан үгсийг тайлбарлахгүй л бол бид яг ямар үйлдлийг ингэж нэрлээд байгааг ойлгохгүй болсон ба нэгэнт түүхэн үг болсныг гэрчилнэ.

Үүнээс гадна шашин суртал, сүм хийд сахил санваартай холбоо бүхий төвөд үг “Тэвш” (Бурхан шашны сургууль ном төгссөн хүний хэргэм, буяны садан, цанид дацанд олон жил сууж их таван ухаанд мэргэжсэн хүнд олгодог цол), “Түүш” (орчуулах ухаанд мэргэжсэн бичгийн хүн, Юань гүрний үеийн хувраг хүний дээд цол, Монгол хэлэнд нэрт орчуулагч, бичгийн мэргэдийг нэрлэнэ, төвөд үг “Гэнэн” (шарын шашны ламын ёсонд байсан гурван янзын сахилын хамгийн хатуу нь, Буянд шадарлах), “Увш” (буянд ойртохын тул бурхны шашны таван зүйлийн цээр), “Гүн” (Манж, Богд хаант улсын үед Монголын феодалын хэрэглэж байсан хэргэм зэргийн дөрөв дэх нь), төвөд үг “Гүнцэг” (үдийн зоог, сүм хийдийн газар дээд лам нарын үдийн зоог) гэх мэт үгс мөн хуучирч түүхэн үг болжээ.

Хуучин үг: Тухайн юм, үзэгдэл, ойлголт нь хэвээр байгаа боловч ойролцоо утга бүхий өөр үгэнд дийлдэн байраа тавьж өгөөд идэвхт чанараа алдсан үгийг хуучин үг хэллэг гэнэ. Үг гэнэт хуучирч байраа тавьж өгдөггүй. Орыг нь эзэлж буй үгтэй нэгэн хэсэг зэрэгцэн оршиж идэвхт чанар нь бууран буурсаар сүүлдээ

хуучирсан үг болдог. Хуучирсан үг хэллэгийн нэг гол онцлог бол тухайн цаг үеийн түүхэн юм, ухагдахуун, хэлний тэмдгийн өвөрмөц чанарыг илэрхийлж байдаг. Хуучирсан үгийн утга гэдэг бол үгийн цөм ба шилжмэл утга хумигдаж утга хэрэглээ өөрчлөгдсөн үзэгдэл юм.

Хуучирсан үг нь ор тас хаягдахгүй, тодорхой хугацааны дараа эргэж сэргэж хэрэглээнд орох тохиолдол бий. Ардчилсан хувьсгал өрнөж, шинэ үндсэн хууль батлагдаж шашин шүтэх эс шүтэх эрхтэй болсноор сүм, хийд, лам, хувраг, да лам, хамба лам, хийморийн сан, гэсгүй гэх мэт үг, эдгээр үгийг дагаад ном унших, ном уншуулах (лам хувь заяа тэгшитгэн сайн сайхныг хүсэж судар уншиж өгөх үйл) хурал ном даган баясах зэрэг өвөрмөц хэллэг ч нэмэгдсэн байна. Энэ мэтчилэн монгол хэлний үгийн сан дахь хуучин болон түүхэн үгийг сэргээн хэрэглэх боломжтой.

Ухагдахуун нь байгаа боловч өөр үгээр нэрлэх үзэгдлийг хуучин үг гэж үзэх бөгөөд зах зээлийн нийгэмд шилжсэн цагаас идэвхтэй хэрэглэгдэх болсон ченж гэх үгээр жишээлэн дурдахад, анх замаас тосон авагч гэж нэрлэж байжээ. “Мал тосон авагч, замаас тосож авах, замаас тосон авч худалдах зэрэг үгс нь ардын засгийн үеийн хууль цаазад нэлээд их хэрэглэгдэх ба энэ нь хямд үнээр худалдан авч, үнийг өсгөж цааш нь дамлан худалдаж ашиг хонжоо олохыг хэлдэг байсан байна.”... Нийслэл хүрээнээ худалдахаар ирэх мал юм зүйлийг зам тосон авагчдыг цаазлан зогсоох учир...”, “мөн Нийслэл хүрээнээс хаяа зальт ард зам тосон авч хонжин мөлжихийг хичээн хураан хадгалж олныг боогдуулан гачигдуулахыг цаазалсугай” гэх мэтээр хууль тогтоомжид бичигдэн үлдсэн байх ба энэ үг нь дамын наймаачин, панзчин, шагчин гэж өөрчлөгдөж явсаар эдүгээ цагт ченж буюу англи хэлний “exchange” 1.Солилцоо, арилжаа 2. Векселийн гүйлгээ 3. Төвийн телефон утасны станц 4. Солилцох, арилжих гэсэн үгнээс үүдэлтэй үгээр солигдсон байна. Энэ үг нь “exchange” буюу эксчэнж гэж дуудагдах боловч хэлэхүйн явцад хэл хэмнэх зарчмаар өмнөх үе нь гээгдэж зөвхөн “ченж” гэдэг нь үлдэж утга нэмэн баяжиж “бөөний үнээр хямд олж авсан валют, эд барааг жижиглэнгийн үнээр худалдан үнийн зөрүүгээс ашиг хонжоо олдог хүн”-ийг заан нэрлэх болжээ. Үүнээс улбаалан махны ченж (махыг бөөний үнээр худалдан аваад жижиглэнгийн үнээр зарж ашиг олдог хүн), валютын ченж (тухайн өдрийн валютын дээд ба доод ханшийг мөрдлөг болгон гадаад, дотоодын мөнгөн тэмдэгтүүдийг солилцох, арилжаалах борлуулах газар), долларын ченж (долларыг хямд үнээр худалдан аваад үнэ нэмж буцаан зарж ашиг олдог хүн), ноолуурын ченж гэх мэтээр үгийн санд идэвхтэй хэрэглэгдэж байна. Ченж гэдэг үгийг Монгол хэлний тайлбар толь бичигт 1.Банк хоорондын валютын солилцоо 2. Бөөний үнээр хямд олж авсан валют, эд барааг жижиглэнгийн үнээр худалдан үнийн зөрүүгээс ашиг хонжоо олдог хүн гэж тайлбарлажээ.

1940 оны хууль, 1924 оны хуульд “Өөрт оногдсон улсын албан байгууллагуудын салаа мөчрийг удирдах бөгөөд тухайн эрхэлсэн хэргийн чанар байдал” гэж орсон байх ба энэ салаа мөчир гэх холбоо үгийг орчин цагийн

монгол хэлэнд салбар гэж хэрэглэх болжээ. Гэвч өвөр монголын бичгийн хэлэнд одоо ч хэрэглэгдсээр байна.

1940-өөд оны үед “авто машины тос бензиний буудал” гэж шатахуун түгээх газрыг нэрийддэг байв. Жишээ нь “Төрөл бүрийн тээврүүдийг нэгтгэсэн төлөвлөгөөтэйгөөр зөвөөр ашиглах ба тэдгээрүүдийг тасралтгүйгээр хөдөлгөж байх явдлуудыг зохиох; 2/ буудлууд, гарашгүйгээр машин тэргийг агуулан хадгалах хэрэглэлүүд хийгээд “авто машины тос бензины буудал” зэргүүдийг өргөнөөр байгуулан автомовил ба ердийн хөсгийн тээврийг элдвээр хангах явдлыг зохиох” гэж зааснаас харж болно. Мөн Орос улсыг айл улс, совет улс, зөвлөлт орос улс, зөвлөлт холбоот улс гэх мэтээр тухайн цаг үеийн онцлогоос шалтгаалан олон янзаар нэрлэж байсан бөгөөд орчин үед Оросын холбооны улс, ОХУ гэсэн товчилсон нэрээр хэрэглэж байна. 1924 оны үндсэн хуульд “ял хөнгөтгөх” гэсэн ойлголт байх ба одоо мөрдөгдөж буй эрүүгийн хуульд “ял хөнгөрүүлэх” гэж хэрэглэж байна. 1924 оны үндсэн хуульд “Ард нийтээр хуралдах цэнгэлдэх ба баяр үйлдэх явдлыг хүндэтгэж”... гэсэн заалт байх ба “баяр үйлдэх” гэдэг нь орчин цагийн монгол хэлэнд “баяр тэмдэглэх” болон өөрчлөгджээ. 1940 оны үндсэн хуульд “боловсруулж байгаа үйлдэхүүн, боловсруулсан үйлдэхүүн” гэж олонтой тааралдах бөгөөд энэ нь орчин цагийн монгол хэлэнд “бүтээгдэхүүн” гэсэн үг болон өөрчлөгдөж хэрэглэгдэж байна. Мөн “газар эдлэх”- “газар ашиглах”, “эд хичээх”- “хулгай хийх”, “улсын сан”- “улсын төсөв”, “шууд зарах”- “зарцуулах, ашиглах, шууд хэрэглэх”, “татварлан авах-татвар авах”, “үдийн хойт”-“үдээс хойш”, “таацуулах- нийцүүлэх” гэх мэтээр өөрчлөгдөн хувирсан байна.

1924 оны хуульд “солиорсон ба ухаан эвдэрсэн бөгөөд зохих газраас шинжлэн батлагдагсдыг сонгох ба сонгогдох эрхгүй” гэж заасан бол 1940 оны хуульд “ухаан мэдрэл эвдрэгсэд” гэж заасан ба 1960 оны хуульд “ухаан солиотой” гэж тус тус өөрчлөгдөж байжээ. Энэ ойлголтыг орчин үед “эрх зүйн чадамжгүй иргэн” гэж томъёолох болсон ба Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.-д “7 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн чадамжгүй байна. 18.2.д “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцно” гэж заажээ. Заан нэрлэж байгаа уг зүйл нь өөрчлөгдөөгүй ч түүнийг нэрлэн хэлэх үг нь ийнхүү өөрчлөгдсөөр ирсэн байна.

Үг хуучрахаас гадна утга хуучирдаг ёс бий. “Чинлүүр” “Цаг хугацааны нэгж, хорин дөрвөн секундтэй тэнцэнэ” гэж тайлбарласан байгаа боловч 1917 оны хуулийн 7 дугаар зүйлд “Аливаа хүн чинлүүр жинг дураар хүнд хөнгөнийг хэрэглэхүй нь их л завших тул хохирохуйд хүрсний дээр харилцан хэрүүл цохион өдүүлэхийн тул хуучин дүрмийн ёсоор үнэхээрийн арван зургаан ланд нийлэлцэх тодорхойг нь хэрэглүүлэхээс гадна Оросын пүүт хэмээх тэгнүүр хэрэглүүлж хүнд хөнгөн жингээр мөлжих муу суртлыг арилгаж цаазалсугай” гэснээс үзэхэд Монголчууд тэгнүүр гэдэг байсан ба чинлүүр жин гэдгээс улбаалж авиа сэлгэх

замаар жинлүүр болсон гэж үзэх магадлал өндөр байна. Мөн 1924 оны үндсэн хуульд Улсын дээд эрхийг хадгалах газруудын эрхлэн шийтгэвэл зохих зүйлсэд “Аливаа хэмжээ чинлүүрийг тогтоох” гэж заажээ. 1924, 1940 оны үндсэн хуульд “эрхлэн шийтгэвэл зохих, шийтгэсэн хэрэг, хэлэлцэн шийтгэх, нэмэгдүүлэн шийтгэх явдал, мэдүүлэн шийтгүүлэх, хянан шийтгэх” гэх мэтээр шийтгэх гэдэг үг олон тохиолдох ба тухайн үед асуудлыг шийдвэрлэх, хэлэлцэх, ажил хэргийг гүйцэтгэх гэсэн утгаар хэрэглэгдэж байжээ. Жишээ нь: Улсын үндсэн хуулийг өөрчлөх батлах явдлыг гагцхүү улсын их хурлаас эрхлэн шийтгэвэл зохино. 1960 оны хуульд “дагаж шийтгэх” гэдэг нь “дагаж мөрдөх” гэсэн утгаар хэрэглэгдэж байв. Харин орчин үеийн монгол хэлэнд “шийтгэх” гэдэг нь “шийтгэл хүлээлгэх, хэрэг шүүн таслах” гэсэн утгаар хэрэглэгдэх болсон байна. Мөн Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос гаргасан Монгол хэлний тольд “шийтгэх” гэдэг үгийг “Шийдэхийн үйлдэгдэх хэв, /хуучин/ 1. Шийдвэрлэх, хийж гүйцэтгэх 2. Хэрэгтэн гэмтнийг шүүн таслах, хэрэг шийтгэх 3. Алдаа дутагдал гаргагсдад цээрлэл үзүүлж адил бус дэсийн шийдвэр гарган торгуулах” гэж тайлбарласан байна. Мөн уг хууль дахь “хянан байцаах, байцаалгах, илтгэн байцаалгах” буюу байцаах гэдэг үг нь тухайн үедээ хянах, нягтлах, нарийн шалгах гэх утгаар хэрэглэгдэж байсан ба орчин үеийн монгол хэлэнд утга нь хувирсан байна. Монгол хэлний их тайлбар тольд “1. Ямар нэг гэмт хэргийг илрүүлэхдээ өчиг мэдүүлэг гаргуулахаар нягтлан асуух 2. Аливаа зүйлийн учрыг олохоор дахин дахин асуух, шалгах 3. Хянан шалгах” гэж тайлбарлажээ. Харин Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос гаргасан монгол хэлний толь бичигт “1. Хянан магадлах, хянан шинжлэх, байцаан судлах 2. Алдаа дутагдлаа задлан шүүмжлэх 3. Шүүх үзүүлэх, хэрэгтнийг шүүх 4. Ялт ажиллагааг хянан магадлах, шүүж ялгах 5. Эл шатны төрийн байгууллагын ажилтны ажил хийгээд хуулийг зөрчиж хариуцлага алдсаныг ялчлан гаргах” гэж тайлбарласан байх ба одоо ч бие байцаалгах, байцаах газар гэх мэтээр 1924 онд хэрэглэгдэж байсан утгаар нь хэрэглэж байна. Харин орчин цагийн монгол хэлэнд цагдаад байцаалгах, өчиг мэдүүлэг өгөх гэсэн утгаар гол төлөв хэрэглэгдэх болжээ.

“Нэгдэл” гэдэг нь үг нь хэвээр боловч утга нь хуучирсны нэг жишээ юм. Үйлдвэрлэлийн хэрэгсэл, хувийн өмчөө нийгэмчилж, хөдөлмөрөө хоршсон хоршоолол гэдэг хуучирсан утга нь байхгүй болсон бөгөөд тухайн цаг үеийн бичвэр, эсвэл тухайн цаг үеийн үйл явдлыг дурдахад хэрэглэгдэж байна. Орчин цагийн аман болон бичгийн хэлэнд “Хүмүүсийн харилцааны найрсаг байдал, санаа бодол нийлсэн хэсэг хүмүүс болон олон нийтийн харилцааны найрсаг, дулаан уур амьсгал” гэх утгаар хэрэглэгдэж байна. Тиймээс нэгдлээс гарах, нэгдлийн гишүүн, нэгдлийн үлгэрчилсэн дүрэм, нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт гэх мэт холбоо үгийн хэрэглээ хумигдан алга болжээ.

1924 оны үндсэн хуулийн 1дүгээр бүлэгт 6 удаа давтагдсан “гадаадын харгисууд, хуучны эзэрхэг харгисын ёс суртал, дотоод гадаадын эзэрхэг харгисын үе, гадаадын эзэрхэг шунахай, гадаад дотоодын харгис шунахай” гэдэг хэллэг нь

тухайн үеийн нийгмийн дарлагч ангийг илтгэж байв. Гэтэл эдгээр үгийг 1940 оны үндсэн хуульд “феодал” гэдэг үгээр орлуулан хэрэглэх болсон байна. Жишээ нь “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улс төрийн үндэс бол феодалын байгууллыг унагааж, ард түмнээс улсын засгийн эрхийг байлдан олж, феодалууд /хан, ван, гүн, тайж, хутагт, хувилгаад/-аас өргөн олон ард түмэнд учруулж байсан улс төр, эдийн засгийн дарлал мөлжил, эрх ямба болон дураар эзэрхэх явдлыг устгасны үрээр үүссэн хөдөлмөрчин /малчин, ажилчин, оюутан/ ардын хурлууд болно” гэжээ. Феодал гэдэг нэр томьёонд хуучин засгийн хэргэм зэрэгтэй, язгуур гарвал өндөр хүмүүс болох хан, ван, гүн, тайж, хутагт, хувилгаадыг заан нэрлэж байв. Харин 1960 оны үндсэн хуульд империалист колонилогчид, империалистуудын түрэмгийлэл гэх мэтээр нэг ухагдахуун ойлголтыг олон янзаар нэрлэж иржээ. Энэ нь шинэ үг хэрхэн хэрэглээнд орж мөн хэрхэн хурдан хуучирдаг болохыг тодорхой харуулж байна.

1924 оны үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд “жилийн наана, батлахын наана” гэж орсон байх бөгөөд энэ үг нь юмны наад тал, дэргэд хажуу тал гэдэг утгаар биш ямар нэгэн цаг хугацаанд хүрэхээс өмнө гэсэн утгаар хэрэглэгдсэн байна. Мөн “хоёр этгээдэд, доод этгээдэд” гэсэн байгаа нь талд, тэр хэсэг газарт гэсэн утгаар хэрэглэгджээ. “Бусдыг хүнд хөнгөний байдалд хирцүүлэн шийтгэх цээрлүүлэх дүрэм хэмжээг хянан зохиолгож...” хирцүүлэх гэдэг нь тохируулах, тааруулах, нийцүүлэх гэсэн утгатай үг байсан ба орчин цагийн хэл бичгийн найруулгад төдийлөн дурдагдахаа больсон больжээ..

Хуучирсан үг хэллэг нийгмийн хүчин зүйлийн нөлөөгөөр шинэ утга аван идэвхтэй үгийн санд буцаж орох нь ч бий. Жишээ нь 1924 оны хуулийн “шинийн зургаан, аргын тоолол, сүсэглэн дагах, түшээ” гэх мэт үг ардчилсан хувьсгал ялж шашин шүтэх эрх чөлөөтэй болсноор эргэж идэвхтэй үгийн санд орох болсон байна. Үүнтэй адил жишээ олныг дурдаж болно. “Төрийн түшмэл, өргөн мэдүүлэх, соёрхон батлах, тамгын газар, шадар сайд, авлигал, цагаач, айлдвар, гэсгээн шийтгэх, гэгээрлийн яам, чуулган, жуух бичиг, арвандолдугаар жаран, төмөр луу жил, өвлийн тэргүүн сар, улаагчин гахай сар, хүчин төгсөхийн барилдлагатай өлзийт сайн улаан морин өдөр, бичин цаг, хаврын тэргүүн хар барс сар, шинийн есөн, өлзийт сайн шар морин өдөр, морин цаг, зарлиг” гэх мэт үгс түүхийн нэгэн цаг үед идэвхтэй хэрэглэгдэж байснаа хэрэглээнээс гарч дахин цаг үе нийгмийн байгуулалт өөрчлөгдөхөд эргэн сэргэж идэвхтэй хэрэглэгдэж байна.

Хуучирсан үгсээс “Түшмэл” гэдэг үгийг он цагийн үүднээс тухайн үед хэрэглэгдэж байсан утгын хамт авч үзвэл 1911 оноос 1930 он хүртэлх бүх оны хууль цаазын бичигт “Түшмэл цэрэг, сайд түшмэл, түшмэл бичээч, байцаагч түшмэл” гэх мэтээр тодорхой албан тушаал эрхэлдэг зэрэг дэв бүхий хүнийг заан нэрлэж эерэг утгаар хэрэглэгдсэн байна. Харин 1930 оны хуульд “Энэхүү татварыг хураалгавал зохих этгээдүүд нь 1. Феодал нар (ван, гүн, тайж, түшмэл) 2. Бүх лам нар. 3. Ашиг эрмэлзэж, худалдаа үйлдвэрийн зэрэг ажилд бусдын

хүчийг хэрэглэх ба жинхэнэ өөрийн бус хүчний орлогоор амьдрах этгээд хэмээн сонгуулийн эрхийг хасагдагчид болно” гэсэн байх ба үүнээс үзэхэд түшмэл хүнийг феодал анги буюу тухайн үеийн нийгмийн дайсан гэж үзэж ноёлогч, дарлагч ангийн эгнээнд оруулж байжээ. Энэ оноос хойш 1995 он хүртэлх хууль цаазын бичигт хэрэглэгдэхгүй байснаа 55 жилийн дараа дахин сэргэж 1995, 2002 оны хуулиудад дахин хэрэглэгдсэн байна. Энэ үгийг тайлбар толь бичигт тайлбарлахдаа хуучирсан үгийн үүднээс тайлбарлаж бичсэн байна. Жишээ нь: “Түшмэл-монголын феодалын төрийн захиргааны байгууллагуудын албан хаагч хүнийг түшмэл гэсэн ерөнхий нэрээр нэрлэдэг байв. Эрхэлсэн түшмэл, туслах түшмэл” гэж 1990 оны толь бичигт тайлбарласан байна. Мөн монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд “Урьдын цагт албан хэргийн талаар таслан тогтоох явдалд оролцох эрх тушаал бүхий хүн гэж тайлбарлаад түшмэл болох, түшмэл эвдэх, дайлаар одуулах түшмэл түүх, зөвлөх түшмэл, түшмэл түшээ, түшмэл шуувин, түшмэл сайд” гэж тайлбарласан байна. Мөн ардын хэвлэлийн хорооны монгол толь бичигт “хуучин цагийн албан эрх тушаал бүхий хүн” гэж тайлбарласан байна. Хэдийгээр ингэж хуучирсан үг хэллэг гэж тайлбарласан байх боловч хуулийн үгийн санд эргэж 2006 оноос дахин хэрэглэгдэх болсон байна. Утгыг он цагийн дарааллаар Хүснэгт 1 харуулав.

1911.12.1	“Хүрээнд сууж байсан манж сайд Сандо-г зайлж гарахыг тулган шаардсан бичиг”	Түшмэл цэрэг
1912.5.12	“Богд хаант Монгол Улсын төлөө олон сайд, хан, ван, гүн, лам нар тангараг барилдах буцалт, няцалтгүй хүчин зүтгэхийг уламжилж ёсоор болгуулсан тухай. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бичиг”	Сайд түшмэл
1913.1.27	“Өмнө хязгаар түгшүүртэй учир цэрэг мордуулж газар орныг хамгаалуулах тухай цэргийн яамны айлтгалыг ёсоор болгосон бичиг”	Дэд зэрэг түшмэл
1914.2.19	“Аливаа нийслэл хүрээний сууж дацан, аймагт захирагдан хурал сургууль үйлдэж бүхий мяндагтан ба гэлэн, гэцэл, санваартай буюу гэнэн боловч, хурал сургуулийн албан хаах лам нарыг хэргийн учир зарлан байцаах шүүх хэрэг тохиолдвоос урьдаар Эрдэнэ Шанзудбын яамнаа мэдэгдэх тухай дүрэм”	Захиран шийтгэх түшмэл
1915.5.7	“Шинээр хууль цааз зохиох газрыг байгуулахаар хэлэлцсэн нь”	Сайд түшмэл
1917.1.12	“Шинэ хууль зүйлийн бичгийг хэлэлцээд хууль зохиох сайд, түшмэдэд илгээсэн бичиг”	Эрхэлсэн түшмэл
1918.5.13	“Аливаа хулгай худлын зэрэг хэрэгт зарлигийг дагаж одоо явуулах цааз хууль”	Эрхэлсэн түшмэл

1919.6.24	“Дотоод яамнаас Улсын хурлын яамыг Дотоод яамны байшинд хуралдуулах болсныг мэдэгдсэн илгээх бичиг”	Түшмэл бичээч
1921.2.14	“Богдоос барон Унгерний тушаалыг хүндэтгэн дагаж байх тухай буулгасан зарлиг”	Түшмэл
1922.3.31	“Улсын албыг нийгэмчлэн гаргуулах тухай”	Алба хугацагдсан түшмэл
1923.2.2	“Богдын шанзав балам нарын хэрэглэлийг хассан тухай”	Төлөөний түшмэл
1925.9. 2	“Аливаа оргосон цэргүүд ба тэд нарыг нэхэн дайчлан бариулсан хошуу шавийн эрх баригчид жич туслан хол болгож оргодуулсан зохигчид нарыг цээрлүүлэн шийтгэхээр тогтоон тушаасан дүрэм”	Цэргийн хэлтсийн эрхэлсэн түшмэл
1926.4.8	“Сүм хийдийн малаас албан татвар хураан авах тухай бичиг”	Төлөөний түшмэл
1927.5.6	“Ардын шүүх таслах газруудын байцаагч түшмэдийн түр дагаж явах дүрэм”	Байцаагч түшмэл
1928.5.25	“Олон аймаг хошуу сумуудын захиргааны газрын албан хаагчдын орон тоо”	Татварын хэлтсийн эрхэлсэн түшмэл
1929.2.14	“Монгол, Хятадын харилцааны тухай”	Эзэрхэг түшмэл
1930.5.27	“Тус улсын бүх улаан цэргийн жинхэнэ албанд татагдах эрхгүй хүмүүсээс тусгай татвар хураахаар тогтоосон дүрэм”	Феодал нар (ван, гүн, тайж, түшмэл)
1995.10.17	“Төрийн захиргааны албаны Зөвлөлийн орон тооны гишүүний цалин, хангамжийн тухай” УИХ-ын 72 дугаар тогтоол.	Тэргүүн түшмэл
2002.12.12	“Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай”	ажлын албаны тэргүүн түшмэл

Хүснэгт 1

Нэг үгийг нөгөө үг нь шахаж гаргаад хуучраадаг байна. Жишээ нь: “авлига”-хуучирсан үг “Өнчдөд хүртээх хишиг, тэтгэмж; [түүхэн үг] Нэг зуун хонь тутмаас нэгийг нь татварлан авч, дайнд амь үрэгдэгсэд, үгээгүй ядууст тусламж болгон олгохоор үүсгэсэн сан”, мөн “өөрийн ажлыг бүтээхийн тулд холбогдох албан тушаалтанд ил, далд өгөх хахууль, Хууль бусаар бусдаас авсан зүйл; ашиг хонжоо”, “ хээл хахууль авах буюу эд ашигт шунаж юмыг ёс бусаар олз болгож авах” гэх мэтээр тайлбар толь бичгүүдэд утгыг тайлжээ. Энэ үг 1991 оны авлигатай тэмцэх хуульд “Хуулийн зорилт нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж хэрэглэгдсэн байх ба түүнээс өмнөх цаг хугацаанд гарсан хуульд “хээл хахууль” гэсэн ойролцоо утгат үг хэрэглэгдсэн байна. “Хахууль, хээл хахууль” гэх үг нь авлига гэсэн

үгийн ойролцоо утгын бүлд хамрагдах ба 1926 оноос 1994 оны хуульд идэвхтэй хэрэглэгдэж байсан нь доорх жишээнээс тодхон харагдана. Мөн улсын ардын аж ахуйн явдалд онц аюултай болох хэрэг өдүүлэн улсын сангийн юмыг холгох үрэгдүүлэх хахууль авах хуурамч зоос үйлдэх зэргийн явдалд холбогдогчдын тухай хэргийг таслан шийтгэх тусгай газар байгуулна.

Дүгнэлт

Үндсэн хуулийн үг хэллэгээс монгол улс түүхийнхээ аль үед ямар улс оронтой эдийн засаг соёл, шашин, улс төр, худалдааны харьцаа хөгжүүлж ирснийг хялбархан мэдэж болно. Ардын хувьсгалаас өмнөх үе, ардын хувьсгал ялсны дараах үе, социализм коммунизмын үе, ардчиллын үеийн үг хэллэгийн нотолгоо болох эдгээр хуулиас үгийн сан ямар хурдан шинэ үгээр баяждаг, мөн хэдий хурдан хуучирч болдгийг тов тодорхой харуулдаг. Хуучин үгийн бүрэлдэхүүнийг авч үзвэл, оноосон нэр, нэр томьёо, харь үг, тэмдэг нэр, орон цагийн нэр, үйл үгийн хуучрал бүгд илэрлээ. Үндсэн хуульд хуучин үгээр үгийн сан баяжсан жишээ олон тохиолдов.

Аливаа ард түмний түүх нь хөрш зэргэлдээ бусад улс орон, ард түмэнтэй улс төр, эдийн засаг, түүх, соёлын харьцаатай байдаг учраас үгийн санд харь хэлний үг орох нь хэлний хөгжлийн зүй ёсны үзэгдэл бөгөөд аль ч улс үндэстний хэлэнд харь гаралтай үг бий. Харь гаралтай үг нь уугуул үгтэй хоршоо, холбоо үг үүсгэн идэвхтэй хэрэглэгдэх эсвэл шинэ заан нэрлэсэн өөр үгэнд байр сууриа алдах эсвэл заан нэрлэсэн ухагдахуун нь алга болсноор хэрэглээнээс гарч түүхэн үг болсон жишээ олон байв. 1952 оноос 1990 оны хооронд хамгийн идэвхтэй хэрэглэгдсэн социализм, социалист, социализмын дайсан, социалист сахилга, социалист аж ахуй, социалист үйлдвэрлэл, социализмын материал, социализм байгуулах, социализмын үйл хэрэг, социализмын эсрэг гэмт хэрэг гэх мэт эдгээр үг нэгэнт түүхэн үг болжээ. Энэ нь тухайн нэрлэгдсэн зүйл нь нийгэм, хүмүүст хэдий хэр хэрэгцээтэй байхаас гадна, ухагдахуунаа хэр зэрэг оновчтой илэрхийлснээс шалтгаалж нийтийн түгээмэл хэрэгцээт үг болох эсвэл хэрэглээ нь хумигдаж идэвхгүй үгийн санд шилжин ордогтой холбоотой.

Abstract:

The lexicon of a language is constantly changing along with the evolution of social development, and old words and expressions that indicate phenomena are removed from the vocabulary, and new phenomena and developments enrich the vocabulary of the language with new words and expressions. In other words, on the one hand, the use of words is reduced and transferred to the ranks of old words, on the other hand, some words that were considered archaic words are included in the neologism resources.

Mongolian words can be classified into active and passive according to their ac-

tive use, and active words can be classified as highly active or colloquial words, and ordinary active or commonly used words. Commonly used words are words that make up the majority of the vocabulary, serve all professions equally, and describe important phenomena of human social relations and life, and are called active words.

Passive words are words that are not often used by the general public and are used by certain professional groups. The passive vocabulary of the Mongolian language includes local dialect words, vulgar words, professional and terminological words, new and old words, etc. This article presents observations on the archaism of the constitution.

Keywords: legal vocabulary, archaic words, historism words, constitution

Ном зүй

- Нансалмаа, Д.** (2015). Үгийн сан судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК. [Nansalmaa, D., Ügiin san sudlal. [Lexicon Studies]. Ulaanbaatar: Udam Soyol LLC. 2015]
- МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн.** (2022). Монгол хэл судлал. Үгийн сан, утга, найруулга судлал. [MUIS-iin Mongol sudlaliin hureelen., Mongol hel sudlal. Ügiin san [Mongolian language studies. Lexicon, semantics, stylistics studies]. Ulaanbaatar: 2022]
- Төмөртоогоо, Д.** (2018). Монгол хэлэнд орсон гадаад үгийн хураангуй тайлбар толь. Улаанбаатар: Адмон принт. [Tumurtogoo, D. Mongol helend orson gadaad ügiin huraangui tailbar toli. [Abridged Dictionary of Foreign Words in Mongolian Language]. Ulaanbaatar: Admon Print. 2018]
- ШУА, ХЗХ.** (2008). Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Улаанбаатар: [MAS, ILL. Mongol helnii delgerengui tailbar toli. [Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences. [Comprehensive explanatory dictionary of Mongolian] Ulaanbaatar: 2008]
- Улсын хэвлэлийн газар.** (1991). БНМАУ-ын түүхийн зарим нэр томьёо. Улаанбаатар хот. State Publishing House. BNMAU-iin tüühiin zarim ner tomiyo. [Some Terms of the History of the Mongolian People's Republic]. Ulaanbaatar: 1991]
- Амарсанаа, Ж. Баярсайхан, Б. Лхагважав, Б.** (2011). Монгол улсын үндсэн хуулийн үгсийн чуулган. Улаанбаатар: [Amarsanaa, J. Bayarsaikhan, B. Lkhagvajav, B. Mongol ulsiin ündsen huuliin ügsiin chuulgan. [Assembly of Words in the Constitution of Mongolia]. Ulaanbaatar: 2011]
- Ардын хэвлэлийн хороо.** (1999). Монгол хэлний толь. [People's Publishing House. Mongol helnii toli. [Dictionary of the Mongolian Language]. 1999]
- Ц.Гантулгабат, Ц.** (2018). Хуульчилсан нэр томьёоны толь. Улаанбаатар: [Gantulgabat, Ts. Huulichilsan ner tomiyonii toli. [Dictionary of Legalized Terms]. Ulaanbaatar: 2018]

МУБИС. (2010). Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар: [MUBIS. Orchin tsagiin mongol hel. [Modern Mongolian Language] Ulaanbaatar: 2010]

Ашигласан хууль, тогтоомж

- 1924 оны Монгол улсын Үндсэн хууль
1960 оны Монгол улсын Үндсэн хууль
1940 оны Монгол улсын Үндсэн хууль
1917 оны 1 сарын 14 “Нийсэл хүрээнд ирэх малыг зам тосож аваад дамлан худалдахыг зогсоох дүрмийг дахин хянуулахаар тогтоосон нь”
1917 оны 8 сарын 19 “Оросын мөнгөн тэмдэгтийн үнийг өөрчлөх саналыг хэрэгсэхгүй болгосон нь”
1917 оны 3 сарын 26 “Нийслэл хүрээнд худалдахаар ирэх зүйлийг замаас тосон авч худалдахыг хориглосон дүрэм”
1917 оны 4 сарын 9 “Аливаа чинээ бүхий наймаачин хүмүүс хөдөө газраас ирэх хонь мал, тос, өвс түлээг зам тосон авах тухай цаазлан зогсоосон тухай дүрэм”
1921 оны 7 сарын 30 “Эрүү шүүлтийн тухай засгийн газрын 8 дугаар хурлын 10 ба 11 дүгээр зүйл”
1992 оны 1 сарын 14 “БНМАУ-ын зам тээврийн яамны дүрэм”

Used laws and regulations

- 1924 Constitution of Mongolia
1960 Constitution of Mongolia
1940 Constitution of Mongolia
January 14, 1917 “On the revision of the rules for stopping the sale of livestock coming to the capital by road”
August 19, 1917 “On the rejection of the proposal to change the value of Russian currency”
March 26, 1917 “On the prohibition of buying and selling goods coming to the capital by road”
April 9, 1917 “On the prohibition of traders of all sizes from buying and selling sheep, cattle, oil, and hay and firewood coming from rural areas by road”
July 30, 1921 “Articles 10 and 11 of the 8th Government Meeting on Torture”
January 14, 1992 “Regulations of the Ministry of Transport , People’s Republic of Mongolia”



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.